

“ТХЗБ: Сургалтын цөм хөтөлбөрийн шинжилгээний үр дүнд суурилан ТХБ-ыг суралцахууд интеграцчилах арга зүй” илтгэлийн хураангуй

Зохиогчид Ч.Нямгэрэл, Н.Нэргүй, Э.Шинэцэцэг

Түлхүүр үг: *Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн зорилго, Тогтвортой байдлын цогц чадамж, Тогтвортой хөгжлийн боловсрол, Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ), Тогтвортой хөгжлийн боловсролыг суралцахууд интеграцчилах, Сургалтын цөм хөтөлбөр*

Судалгаанд оролцогчид: Судалгаанд МУИС, БМДИ, БХ, МУБИС, БСШУЯ, “Тэгш таван ухаан боловсролын төв” НҮТББ, “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв” НҮТББ, “Бодит чадвар академи” НҮТББ, “Англи хэлний багш нарын холбоо” НҮТББ, Нийслэлийн 11-р сургууль, “Орхон хасу” сургууль, Мон-Турк сургууль, Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэсийг тус тус төлөөлсөн 50 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан.

Зорилго: Сургалтын хөтөлбөрт ТХЗБ-ын интеграцилагдсан байдлыг илрүүлэх судалгаанд суурилан ТХБ-ыг сургалтын хөтөлбөрт интеграцилах шинэлэг арга зүй боловсруулах

Арга зүй: Судалгааны объект болгож “цөм хөтөлбөр” гэсэн ерөнхий нэг нэр томъёогоор ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн сургалтын цөм хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд суралцахууд удирдамж, сурах бичгүүдийг нэмж, нийт 230 гаруй сургалтын үндсэн баримт бичгийг ашигласан. “Цөм хөтөлбөр”-т 2019 оны сайжруулалтын өмнөх баримт бичгүүд хамрагдсан хязгаарлалттай Судалгааны арга зүйг боловсруулахын тулд ТХ, ТХБ, ТХЗ-ын чиглэлээр сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-оос гаргасан онол арга зүйн удирдамжууд, зарим улс орны сүүлийн жилүүдийн энэ чиглэлийн судалгаанууд, олон улсад нэртэй эрдэмтдийн эрдэм шинжилгээний зарим өгүүлэлийг нарийвчлан судалсан. Судалгааны арга хэрэгсэл: Судалгаанд “Матриц 1” ба “Матриц 2” гэж нэрлэсэн Excel-ийн автоматчилагдсан тусгай программуудыг бүтээж ашигласан. ТХЗБ-ын үзэл санаа, агуулга, арга зүй нь цөм хөтөлбөрт хэрхэн интеграцчилагдсан байдлыг үнэлэх шалгуураар ЮНЕСКО-ийн “ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуудын зорилт”¹ (2017) удирдамжид өгөгдсөн ТБ-ын 8 цогц чадамж, ТХ-ийн 17 зорилго тус бүрийн хүрээнд тодорхойлсон нийт 255 суралцахуудын зорилт, 171 сэдэв, 119 арга хандлага, арга, техникийг тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт үнэлгээ хийх хүчин чадалтай байхаар дээрх хоёр матрицыг бүтээсэн болно. Матриц 1 нь цөм хөтөлбөрүүд дэх суралцахуудын зорилтод ТХБ-ын *агуулга* буюу ТХЗБ-ын хүрээнд санал болгосон сэдвүүдийн интеграцчилагдсан байдлыг шинжлэх, харин Матриц 2 нь ТХЗБ-ийн сэдвүүдтэй интеграцчилагдсан гэж тогтоогдсон цөм хөтөлбөрийн суралцахуудын зорилтыг ТХЗБ-д санал болгосон арга техниктэй хэрхэн интеграцчилж болохыг, улмаар ТБ-ын аль цогц чадамжийн төлөвшилд ямар хувь оруулах боломжтойг тогтоож, үндэслэлийг илрүүлэх зориулалттай. Мөн дээрх арга хэрэгсэлийн тусламжтайгаар илрүүлсэн судалгааны үр дүнг ашиглан ТХБ-ыг аль ч ангийн ямар ч хичээлийн нэгж хөтөлбөрт интеграцчилж болох тусгайлсан арга зүйг багш нарт зориулан бүтээж, 45 нэгж хичээлийн жишээг боловсруулсан.

Үр дүн: Цөм хөтөлбөрийн нийт 6 чиглэлийн 24 судлагдахуунаар боловсролын 3 түвшинд ТХЗБ нь цөм хөтөлбөрийн агуулга, суралцахуудын зорилт, арга зүйд хэрхэн тусгагдсан байдлыг тэдгээрийн давтамж, тархалтаар тодорхойлж, харгалзах хамаарал, зүй тогтлуудыг илрүүлсэн. Тухайлбал, Агуулгын интеграцыг илрүүлэх судалгаагаар ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрөөс давхардсан тоогоор нийт 567 суралцахуудын зорилт ТХЗБ-д хамаарч байгааг, тэдгээрийг хэрэгжүүлэхэд ТХЗБ-ын арга хандлагын 4 төрлийн аргад харгалзах давхардсан тоогоор 895 арга, техникийг хэрэглэж

¹ “Education for SDG: Learning objectives” буюу “ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуудын зорилтууд” гэсэн ЮНЕСКО-ийн удирдамжид анх удаа “ТХЗ-ын төлөөх боловсрол” гэсэн нэр томъёо хэрэглэгдсэн бөгөөд энэ шинэ төрлийн гэж ойлгож болохоор боловсролын суралцахуудын зорилт, холбогдох агуулга, арга техникүүд тодорхойлогдсон болно. Иймд бид цаашид энэ нэр томъёог “ТХЗБ” гэж товчлон хэрэглэнэ.

болохоор, мөн ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах 957 боломж байгаа нь тус тус илрүүлэн тодорхойлсон.

Дүгнэлт: Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт *ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн интеграцчиглагдсан* байна. Цаашид цөм хөтөлбөрийг сайжруулахад шаардлагатай тодорхой зөвлөмжүүдийг гаргасан.